



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/117

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Цэцэг сумын нутаг дэвсгэрт шинээр баригдах 4.9 км урттай авто замын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: С.Мөнх-Очир - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Нямжаргал - Төрийн бус байгууллагын төлөөлөл

О.Энхтунгалаг - Хувийн хэвшлийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:
Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын Өмчийн
харилцааны ахлах мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Ганзориг /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ц.Даваасамбуу/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2019 тг А/117 Чх
02 00531